

МИГ ДААТГАЛ ХХК

Монгол Улс, Улаанбаатар хот, СБД, 1-р хороо, 13-р хороолол,
Парисын гудамж, Ай Си Тауэр, 9 давхар, МИГ Даатгал ХХК
Утас: +976-7575-6000 Ц/шуудан: info@mig.mn
Ц/хуудас: www.mig.mn

2025.05.16 № 01/12-543

танай _____ -нь № _____ -т

Хяналтын журмаар гомдол гаргах тухай

Миг даатгал ХХК-ийн гомдолтой, Санхүүгийн зохицуулах хорооны улсын байцаагч М.Тамирт хариуцагдах захиргааны хэргийг хянан хэлэлцсэн Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2025 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 221/МА2025/0312 дугаар магадлалыг бүхэлд нь эс зөвшөөрч, анхан болон давж заалдах шүүхийн хууль хэрэглээний зөрүүг арилгах, хуулийг Улсын дээд шүүхийн тогтоол, тайлбараас өөрөөр хэрэглэсэн, хууль хэрэглээг тогтооход зарчмын хувьд нийтлэг ач холбогдолтой байх үндэслэлээр хяналтын журмаар гомдол гаргаж байна.

Санхүүгийн зохицуулах хорооны байцаагч иргэн Б.Золжаргалын даатгалын тохиолдол үүссэн эсэх талаарх маргаан, гомдлыг авч үзээд 2024 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 3/2646 дугаар албан бичгээр нөхөн төлбөр олгох асуудлыг шийдвэрлэж, хариу мэдэгдэхийг Миг Даатгал ХХК-д даалгасан. Уг албан бичгийн хариуг тогтоосон хугацаанд буюу 07 дугаар сарын 30-ны өдрийн 01/12-1148 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Худал дуудлага өгсөн, даатгалын тохиолдолд болсон эсэхийг нотлох ямар ч баримт үгүй тул татгалзах хууль зүйн үндэслэлтэйг уг албан бичигт тодорхой дурдсан болно.

Хариуцагчийн 2024 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн Эрх бүхий албан тушаалтны 2401000039 дугаар Зөрчлийн хэрэг нээх тухай тогтоол нь Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны 2024 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 3/2646 дугаар албан бичгийг биелүүлээгүйг үндэслэж зөрчлийн хэрэг нээсэн бөгөөд уг хэрэгт Зөрчлийн тухай хуулийн 11.13-р зүйлийн 15 дахь хэсгийн 15.18-д заасан эрх бүхий байгууллагаас өгсөн даалгаврыг биелүүлээгүй гэх үндэслэлээр шийтгэл ногдуулсан нь үндэслэлгүй байна гэж үзэж нэхэмжлэгч шүүхэд гомдол гаргасныг анхан шатны шүүх хангаж, шийтгэлийн хуудсыг хүчингүй болгож шийдвэрлэсэн.

Давж заалдах шатны шүүхээс анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, гомдлыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож, хариуцагчийн давж заалдах гомдлыг хангаж шийдвэрлэсэн нь хэргийн үйл баримтыг бүрэн зөв үнэлж чадаагүй, хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн, уг хуулийг Улсын дээд шүүхийн тогтоолоос өөрөөр хэрэглэсэн байна. Энэхүү Эрх бүхий албан тушаалтны 2401000039 дугаар Зөрчлийн хэрэг нээх тухай тогтоол нь Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны 2024 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 3/2646 дугаар албан бичгийг биелүүлээгүйг үндэслэж зөрчлийн хэрэг нээсэн бөгөөд уг хэрэгт Зөрчлийн тухай хуулийн 11.13-р зүйлийн 15 дахь хэсгийн 15.18-д заасан эрх бүхий байгууллагаас өгсөн даалгаврыг биелүүлээгүй гэх үндэслэлээр шийтгэл ногдуулсан нь үндэслэлгүй байна. Үүнд:

1. Санхүүгийн зохицуулах хорооны Эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3-т зааснаар ажлын албаны дарга нь Хорооны ерөнхий менежер байна гэдэг агуулгыг Хороог төлөөлөх бүрэн эрхтэй, Хуулиар Хороонд тусгайлан олгосон эрх үүргийг хэрэгжүүлэх эрхтэй гэж тайлбарлаж буй нь үндэслэлгүй байна.

2. Санхүүгийн зохицуулах хорооны эрхзүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6-д болон 33 дугаар зүйлийн 33.1 дэх заалтуудад хорооны эрх хэмжээг тодорхой заасан байна. Дээрх заалтын зохицуулалтаар Санхүүгийн зохицуулах хороо нь хамтын удирдлагатай байгууллага буюу хорооны гишүүдийн тогтоолоор шийдвэрээ гаргадаг. Энэхүү эрх хэмжээгээ менежер буюу ажлын албаны даргад шилжүүлэх эрхгүй болохыг хуулиар тодорхойлсон байна.

3. *Хороо өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар зөвшөөрөл эзэмшигчдийн хооронд болон зөвшөөрөл эзэмшигч, үйлчлүүлэгчийн хооронд гарсан маргааныг урьдчилан шийдвэрлэнэ* гэж заасны дагуу даатгагч болон даатгуулагч нарын хооронд үүссэн нөхөн төлбөрийн маргааныг дээр дурдсан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.3-т заасны дагуу шүүхийн өмнөх шатны урдьчилан шийдвэрлэх журмын хангах хэлбэр бөгөөд нөхөн төлбөр олгох, нөхөн төлбөр эс олгох 2 үндэслэлийн хэмжээнд зөвхөн мэргэжлийн байгууллагын дүгнэлт өгдөг ба гэрээний талууд иргэний хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргаж маргаанаа шийдвэрлүүлэх боломжтойг албан бичгээр зөвлөмж өгдөг тул, Даатгалын тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.1.10-т заасан даалгаврын шинж, хэлбэрийг агуулаагүй, албадлагын арга хэмжээ авах шийдвэр гараагүй байна

4. Энэ талаар Улсын дээд шүүхийн 2016 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 440 дүгээр тогтоолоор даатгалын тохиолдлын хувьд даалгавар даалгах эрхгүй болохыг хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах хүрээнд тайлбарлаж хэрэглэсэн байтал энэ талаар тогтоолоос өөрөөр хэрэглэж хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн байна. Хуульд зааснаас давсан эрх хэмжээ хэтрүүлсэн түүнийг нь даалгавар гэж буруу тайлбарлан хэрэглэсэн давж заалдах шатны шүүхийн дүгнэлт үндэслэлгүй байна.

5. Эрх бүхий байгууллагаас өгсөн даалгавар гэх Ажлын албаны 3/2646 дугаар албан бичигт ... даатгалын гэрээнд заасан эрсдэлийн улмаас даатгуулагчид учирсан хохирлын нөхөн төлбөр олгох асуудлыг шийдвэрлэж, шийдвэрийн талаарх мэдээллийг 07 дугаар сарын 30-ны дотор .. хариу мэдэгдэхийг даалгасан. Бид даатгалын гэрээнд зааснаар буюу гэрээний 8.2.3-д зааснаар даатгуулагч худал мэдээлсэн, хохирлын шалтгаан тодорхой бус, нөхөн төлбөрийг шийдвэрлэх үед хохирлын шалтгааныг тогтоох боломжгүй болсон хохирол гэж заасны дагуу нөхөн төлбөр олгохоос татгалзаж шийдвэрлэсэнээ 07 дугаар сарын 30-ны өдрийн 01/12-1148 дугаар албан бичгээр хариу мэдэгдсэн болно. Өөрөөр хэлбэл энэхүү албан бичиг нь мэдэгдлийн агуулгатай байх бөгөөд хэрхэн шийдсэнээ тогтоосон хугацаанд мэдэгд гэснийг биелүүлсэн атал ийм үндэслэлээр зөрчлийн хэрэг үүсгэн шийтгэсэн нь хууль зүйн үндэслэлгүй байна.

Даалгавар нь хууль зүйн агуулгаар хоёргүй утгаар хэрэглэгдэх төрийн захиргааны байгууллага хуулиар тогтоон олгосон эрх хэмжээнийхээ хүрээнд эрх бүхий этгээдийн шийдвэр бүхий албан ёсны заавар чиглэл юм. Гэтэл дээрх албан бичгийг албан даалгавар гэж дүгнэсэн нь үндэслэлгүй байна. Нэгт, ажлын албаны дарга хороог төлөөлөх бүрэн эрх олгогдоогүй байна, хоёрт уг бичиг хэрхэн шийдсэнээ мэдэгд гэсэн агуулгатай мэдэгдэл байна.

6. Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 3/2646 дугаар албан бичгээр Миг Даатгал ХХК-д хандаж нөхөн төлбөр олгохоос үндэслэлгүй татгалзсан болохыг тогтоож Б.Золжаргалд нөхөн төлбөрийг олгож, хариу мэдэгдэхийг үүрэг болгосон нь нэхэмжлэгчид эрх зүйн үр дагавар үүсгэсэн, тодорхой нэг тохиолдлыг зохицуулсан захирамжилсан шийдвэр байх тул уг албан бичиг нь захиргааны актын шинжийг бүрэн агуулж байна. Энэ тохиолдолд захиргааны байгууллага нь өөрийн бүрэн эрхэд хамааралгүй гомдлыг буюу иргэний хэргийн шүүхээр шийдвэрлэх эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэж, өөрт олгогдсон эрх хэмжээгээ хэтрүүлсэн гэж үзэж байна.

7. Санхүүгийн зохицуулах хорооны Эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6-д зааснаар Санхүүгийн зохицуулах хороо нь тусгай зөвшөөрөл эзэмшигч, үйлчлүүлэгчийн хооронд гарсан маргааныг эрх хэмжээнийхээ хүрээнд хянан шийдвэрлэнэ, мөн хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д зааснаар өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар ... тусгай зөвшөөрөл эзэмшигч, үйлчлүүлэгчийн хооронд гарсан маргааныг урьдчилан шийдвэрлэхээр тус тус зохицуулсан байдаг. Эндээс үзэхэд Санхүүгийн зохицуулах хороо нь тусгай зөвшөөрөл эзэмшигч Миг Даатгал ХХК болон гуравдагч этгээд Б.Золжаргалын хооронд үүссэн бүх маргааныг шийдвэрлэхгүй, зөвхөн өөрийн эрх хэмжээ, чиг үүрэгт хамаарах асуудлаар гарсан маргааныг өөрийн эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэх ёстой.

8. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.4, Даатгалын тухай хуулийн 13.1.1 дэх хэсэгт даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд тавих Санхүүгийн зохицуулах хорооны хяналт, чиг үүрэг, оролцооны хүрээг тодорхойлсон бөгөөд даатгагч, даатгуулагчийн хооронд үүссэн, даатгалын гэрээний үүргийн гүйцэтгэл, хохирол, төлбөртэй холбоотой асуудлаарх маргааныг шийдвэрлэх, хохирол төлбөрийг гэрээний аль нэг талд хариуцуулахаар тогтоох, хэн аль нь хохирсон талаар дүгнэлт гаргах эрхийг Санхүүгийн зохицуулах хороонд олгоогүй байх тул маргаан бүхий захиргааны актаар нэхэмжлэгчид "... төлбөр төлж, хариу мэдэгдэх"-ийг даалгасныг захиргааны байгууллагын өөрийн "эрх хэмжээний хүрээнд" гэж үзэх боломжгүй байна.

9. Захиргааны хэргийн шүүх нь захиргааны байгууллагын үйл ажиллагааг хянахдаа юуны түрүүнд захиргааны байгууллага өөрт нь харьяалан шийдвэрлэх өргөдөл, гомдлыг шийдсэн эсэх, тухайн асуудлаар шийдвэр гаргах эрх хуулиар олгогдсон эсэхийг нягтлан шалгах ёстой.

Миг Даатгал ХХК болон Б.Золжаргал нарын хооронд даатгалын гэрээ байгуулсан бөгөөд даатгалын гэрээний үүрэгтэй холбогдуулан талуудын хооронд маргаан үүсэж, улмаар Б.Золжаргалаас Санхүүгийн зохицуулах хороонд хандаж, Миг Даатгал ХХК-ийг даатгалын нөхөн төлбөр төлөхөөс үндэслэлгүйгээр татгалзсан талаар гомдол гаргасан. Хэдийгээр Санхүүгийн зохицуулах хороо иргэдийн гомдол өргөдлийг хянан шалгах, тухайлбал даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа явуулсан эсэхийг шалгаж тогтоох, захиргааны шийтгэл оногдуулах, тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааг түр зогсоох эрхтэй боловч "Нөхөн төлбөр олгохыг даалгах" шийдвэр гаргах эрхгүй байна.

Даатгалын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэгт зааснаар даатгагч, даатгуулагчийн хооронд үүсэх гэрээний харилцааг Иргэний хуулиар зохицуулах, мөн хуулийн 82 дугаар зүйлийн 82.1 дэх хэсэгт зааснаар аливаа этгээдийн даатгалын үйл ажиллагаатай холбогдон гарсан маргааныг Зохицуулах хороонд тавьж шийдвэрлүүлэх бөгөөд шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд давж заалдахаар зохицуулснаас үзэхэд даатгалын гэрээний талуудын хооронд үүссэн маргааныг иргэний шүүх шийдвэрлэх юм.

Мөн Санхүүгийн зохицуулах хорооны байцаагчийн бие даан гаргасан шийдвэр нь Санхүүгийн зохицуулах хорооны Эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-т “Хороо хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэр гаргах бөгөөд түүнд Хорооны дарга гарын үсэг зурна” гэж, 8.2-т “Бүрэн эрхийнхээ хүрээнд Хорооны гаргасан шийдвэр тогтоол хэлбэртэй байна” гэж тус тус заасныг зөрчин, захиргааны байгууллагыг төлөөлж эрх бүхий этгээдүүдийн өмнөөс шийдвэр гаргасан үйлдэл нь хууль бус бөгөөд үүрэг болгосон албан бичиг нь тогтоол хэлбэрээр биш тул эрх зүйн үр дагавар үүсэх үндэслэлгүй байна.

Иймд дээрх үндэслэлүүдээр хэргийг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцэж, Захиргааны давж заалдах шатны шүүхийн 2025 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 221/МА2025/0312 дугаартай магадлалыг хүчингүй болгож, Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж өгнө үү.

Хүндэтгэсэн,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



С. АНУУЖИН